

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 83 хувь нь хэрэгжсэн байна.

АУДИТЫН КОД: ХЭА-2026/05-22-ШТА-НА

“УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”-Д ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТ

Хэрлэн сум 2026 он



Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ж.Ганбаатар

Утас: 70562112 Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа

Утас: 92116773 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор Д.Эрдэнэбилэг

Утас: 92116770 Цахим хаяг: erdenebilegd@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Билэгсайхан

Утас: 88032817 Цахим хаяг: bilegsaikhants@audit.gov.mn

Аудитор Т.Алтаншагай

Утас: 92116768 Цахим хаяг: altanshagait@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn



Аудитыг гүйцэтгэсэн:

Хэнтий аймаг дахь
Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх
аудитор Ж.Ганбаатар

Аудитын менежер
Д.Оюунтуяа

Ахлах аудитор:
Д.Эрдэнэбилэг
Ц.Билэгсайхан

Аудитор:
Т.Алтаншагай

Аудитын тайлан,
дүгнэлт, зөвлөмжтэй
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах, холбогдох
саналаа өгөхийг хүсвэл
70562112 дугаарын
утсаар харилцана уу.

Аудитын тайланг УАГ-
ын www.open.audit.mn
цахим хуудаснаас үзнэ
үү.

Хаяг: Хэнтий аймаг дахь
Төрийн аудитын газар

Хэрлэн сум, 4-р баг,
аймгийн Засаг даргын
Тамгын газрын байр

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....7

БҮЛЭГ 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээ нь хөрөнгө оруулалтын төсөвлөлтийн шаардлагад нийцэхгүй байна. 11

1.1. Хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан, нэн тэргүүнд хэрэгцээ, шаардлагатай төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна. 11

1.2. ТЕЗ нь төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулж тэнцүү хуваарилж төлөвлөөгүй байна..... 12

БҮЛЭГ 2. Захиалагчаас ажлын тоо хэмжээг хүргүүлэхдээ төлөвлөгөөнд заасан хугацааг баримтлаагүйгээс худалдан авах ажиллагааг хугацаанд нь зохион байгуулах боломжгүй болсон байна. 14

2.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хуулийн хугацаанд боловсруулан батлуулсан ч захиалагчаас ажлын тоо хэмжээг гаргаж төлөвлөгөөнд заасан хугацаанд хүргүүлээгүй байна. 14

2.2. Худалдан авах ажиллагааны явцад гомдол гараагүй байна. 16

БҮЛЭГ 3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 83.0 хувь нь бүрэн хэрэгжсэн ч техникийн хяналт хэрэгжүүлсэн эсэх нь тодорхойгүй байна. 16

3.1. Төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн хугацаанд нь санхүүжүүлсэн байна. 16

3.2. Төсөл, арга хэмжээнд захиалагчийн техник хяналт хэрэгжүүлсэн ч фото зургаар баримтжуулан тайлагнаагүй байна..... 17

3.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлыг бүрэн бүртгэж, зориулалтын дагуу ашиглаж байна. 19

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:20

ДҮГНЭЛТ: 21

ЗӨВЛӨМЖ:21

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2026 оны 04 дугаар сарын 09

Дугаар А/08


Чингис хот

Г Нийцлийн аудитын тайлан 7
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсэг, 2025 оны А/161 дугаар тушаалаар баталсан "Аудитын шийдвэр, түүний хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, 2025 оны А/175 дугаар тушаалаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" нийцлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Худалдан авах ажиллагааны газар, Хэрлэн сумын Засаг даргад тус тус хүргүүлэхийг ахлах аудитор /Д.Эрдэнэбилэг/-т үүрэг болгосугай.
3. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүртгэж, Аудитын шийдвэрийн хэрэгжилтийн газарт хүргүүлэхийг ахлах аудитор /Д.Эрдэнэбилэг/-т даалгасугай.
4. Аудитаар өгсөн албан шаардлагыг тогтоосон хугацаанд, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Аюурбуны/-д зөвлөсүгэй.
5. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож, тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтаар хадгаламжийн нэгж үүсгэн байгууллагын архивт хүлээлгэн өгөхийг ахлах аудитор /Д.Эрдэнэбилэг/-т үүрэг болгосугай.
6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Д.Оюунтуяа/-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, Тэргүүлэх аудиторын 2025 оны
04 дугаар сарын 09 ны өдрийн А/08 дугаар
тушаалын хоёрдугаар хэвсрэлт

"Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" нийцлийн аудитгаар
өгсөн албан шаардлагын жагсаалт
1825040017 9074082

№	Зөрчил хариуцах		Зөрчлийн утга	Албан шаардлагын дугаар	Дүн /төгрөг/
	Байгууллага	албан тушаалтан			
1	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	дарга Б.Сүнгээ	"Чингис хотын бохир усны төв коллекторын 1,2,3,4 дүгээр шугамын шинэчлэл, даралтат шугам, өргөх станц /Хэнтий, Хэрлэн сум/, "Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Хэнтий, Мөрөн сум/" төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн талаар ажлын тайлан, фото зургаар баримтжуулаагүй	292-A2360446 ХЭА-2026/05-22-ШТА-НА	
2	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Засаг дарга Д.Аюурбунь	Магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй, техникийн нөхцөлгүй 324.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээг 4 сумын ИТХ-аар, 420.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сумын төвийн гэрэлтүүлэг, камержуулалт /Жаргалтхаан/ нь зураг төсөв, техникийн нөхцөлгүй байхад аймгийн ИТХ-аар батлуулсан	296-A2371043 ХЭА-2026/05-22-ШТА-НА	977,623,633.0
3	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Засаг дарга Д.Аюурбунь	ОНХО-аар ажлын даалгаваргүй 235.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 ТАХ, техникийн тодорхойлолтгүй 206.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 ТАХ-г төлөвлөсөн.	295-A2371043 ХЭА-2026/05-22-ШТА-НА	442,395,890.0
4	Худалдан авах ажиллагааны газарт	Дарга Т.Батдорж	1. "Сумын эрүүл мэндийн төвийн машин", "Сумын Засаг даргын Тамгын газрын автомашин"-ы гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хорооны хуралд аймгийн ЗД-ын 2025 А/201 дүгээр захирамжаар томилоогүй иргэний төлөөлөл оролцсон. 2. Үнэлгээний хороо нь 100.0 сая төгрөгийн төсөвт өртөг, санхүүжих дүнтэй "Сумын эрүүл мэндийн төвийн машин" төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй санал ирүүлсэн гүйцэтгэгчийг шалгаруулсан. 3. Техникийн тодорхойлолтод заасан шаардлага хангаагүй, зах зээлийн үнээс өндөр үнэтэй хөрөнгийг бэлтгэсэн.	291-A2361113 ХЭА-2026/05-22-ШТА-НА	100,000,000.0
5	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Засаг дарга Д.Аюурбунь	"Батширээт сумын ЗДТГ-ын байрны засвар" ТАХ-г хэрэгжүүлэх эрхийг Батширээт сумын Засаг даргад шилжүүлсэн боловч хяналтыг хэрэгжүүлээгүйгээс гэрээний хугацаанд хэрэгжиж дуусаагүй.	294-A2360446 ХЭА-2026/05-22-ШТА-НА	
6	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Засаг дарга Д.Аюурбунь	Аймгийн Засаг даргын 2025 оны А/46 дугаар захирамжаар байгуулсан комисс нь "Мөнгөн шил-Шилэн хийц" ХХК-аас авто машиныг хүлээн авахдаа техникийн тодорхойлолтод нийцээгүй, гүйцэтгэгчийн санал болгосноос өөр 176.5 сая төгрөгийн "Toyota 4Runner" маркийн автомашиныг хүлээн авсан.	290-A2361113 ХЭА-2026/05-22-ШТА-НА	176,500,000.0
7	Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар	Засаг дарга Д.Эрдэнэбаатар	Засгийн газрын 2021 оны 212 дугаар тушаалаар баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийг зөрчин Хэрлэн сумын Засаг дарга ашиглалтад оруулах комиссыг томилон барилга байгууламж, их засварын 3 төсөл, арга хэмжээг хүлээн авсан.	293-A2360446 ХЭА-2026/05-22-ШТА-НА	
ДҮН					1,696,519,490.0

	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР
ААТҮГ	Аж ахуйг тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МЕД	Магадлалын ерөнхий дүгнэлт
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
<i>Дүрслэл 1</i>	<i>Төсөл, арга хэмжээний ангилал</i>	13
<i>Дүрслэл 2</i>	<i>Төлөвлөгөөнөөс хоцорсон хугацаа</i>	15
<i>Дүрслэл 3</i>	<i>Төсөл, арга хэмжээний хэрэгжилт</i>	16

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
<i>Зураг 1</i>	<i>Чингис хотын инженерийн шугам сүлжээний ажил</i>	18

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
<i>Хүснэгт 1</i>	<i>Аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдсан эсэх</i>	11
<i>Хүснэгт 2</i>	<i>Магадлалаар баталгаажсан зураг төсөв, газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлтэй эсэх</i>	12
<i>Хүснэгт 3</i>	<i>Өмнөх оноос шилжих төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжүүлэхээр төлөвлөсөн дүн</i>	13
<i>Хүснэгт 4</i>	<i>Хөрөнгө бүртгэсэн байдал</i>	19

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл <p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дах хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2025 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2025 оны А/179 дүгээр тушаалыг үндэслэн тус аудитыг хийж гүйцэтгэлээ.</p>
Аудитын зорилт	<p>“Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдлээ.</p> <p>Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">• Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөсөн эсэх,• Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж хяналт тавьсан эсэх,• Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх,
Аудитын хамарсан хүрээ	<p>Аудитад аймгийн ЗДТГ, ГХБХБГ, ОНӨГ, ХАА газар зэрэг төрийн байгууллагууд, хөрөнгө оруулалтыг гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан аудитыг хийж гүйцэтгэлээ</p>
Аудитын арга зүй	<p>Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол улсын төрийн аудитын стандарт MNS 6817-7:2020, Гүйцэтгэлийн аудитын зарчим, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэн баримт материал нягтлан шалгах зэрэг судалгааны арга зүйг ашигласан.</p>

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Барилгын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”;
- Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр;
- Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”;
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”;
- Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2023 оны А/261, 2025 оны А/106 дугаар тушаалаар тус тус баталсан баталсан “Харьцуулалтын аргаар үйлчилгээ авах тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”;
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон холбогдох аргачлалууд”;
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд;
- Батлагдсан зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон холбогдох бусад эрх зүйн актууд.

Аудит багийн бүрэлдэхүүн, хугацаа	хийсэн	Аудитыг газрын дарга, Тэргүүлэх аудитор Ж.Ганбаатар хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа хэрэгжүүлэн ахлах аудитор Д.Эрдэнэбилэг, Ц.Билэгсайхан, аудитор Т.Алтаншагай нар 2026 оны 01 дүгээр сарын 21-ны өдрөөс 04 дүгээр сарын 10-ны хооронд хийж гүйцэтгэлээ.
Хүндрэл бэрхшээл		

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд Хэнтий аймагт 30,321.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 4,733.1 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 6 төсөл, арга хэмжээний хэрэгжүүлэх эрхийг орон нутагт шилжүүлсэн байна.

Эдгээрээс 2025 онд 4 төсөл, арга хэмжээ он дамжин, 2 төсөл, арга хэмжээ шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан бөгөөд үүнээс их засварын 1, барилга байгууламжийн 5 төсөл, арга хэмжээ байна.

Хэрэгжих салбараар нь авч үзвэл дэд бүтцийн салбарын 3, боловсролын салбарын 2, төрийн захиргааны салбарын 1 төсөл, арга хэмжээ байна.

Шинээр хэрэгжүүлэх 2 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгчийг шалгаруулж 373.4 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гарсан боловч 2025 оны 7 дугаар сарын 9-ны өдрийн “Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулиар дээрх 2 төсөл, арга хэмжээний төсвийг гэрээний дүнгээр тодотгон баталсан байна.

Нийт гүйцэтгэгчтэй 30,146.0 сая төгрөгийн гэрээ байгуулснаас 15,785.7 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ бүрэн дуусч, 11,611.3 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ онд дамжин хэрэгжиж байгаа бол, 2,749.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Тайлант онд гүйцэтгэлээр 2,608.1 сая төгрөгийн санхүүжилт олгож, 15,785.7 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг Өмнөдэлгэр сум, Бэрх тосгоны холбогдох байгууллагуудад бүрэн бүртгэж, санхүүгийн тайланд тусгасан байна.

БҮЛЭГ 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх зарим төсөл, арга хэмжээ нь хөрөнгө оруулалтын төсөвлөлтийн шаардлагад нийцэхгүй байна.

1.1. Хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан, нэн тэргүүнд хэрэгцээ, шаардлагатай төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжих орон нутагт эрх шилжүүлсэн 6 төсөл арга хэмжээний 4 нь өмнөх оноос дамжин хэрэгжих, 2 төсөл арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан байна.

Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 2 төсөл, арга хэмжээг Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн байдлыг хянавал:

- ✓ *Ерөнхий боловсролын сургуулийн их засвар /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/*
- ✓ *Чингис хотын бохир усны төв коллекторын 1,2,3,4 дүгээр шугамын шинэчлэл, даралтат шугам, өргөх станц /Хэнтий, Хэрлэн сум/ төсөл арга хэмжээнүүд нь Монгол улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн 3.2.9¹, Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 3.2.1², 2.3.2.6³-д гэх зорилтуудтай нийцүүлж төлөвлөсөн байна.*

Эх сурвалж: Монгол Улсын Их хурлын 2024 оны 35 дугаар тогтоол “Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай”

Мөн аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан дээрх 6 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Хүснэгт 1. Аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдсан эсэх

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа	Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцсэн байдал
1	Чингис хотын бохир усны төв коллекторын 1,2,3,4 дүгээр шугамын шинэчлэл, даралтат шугам, өргөх станц /Хэнтий, Хэрлэн сум/	2025 2027	2.4.2.1.1
2	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Хэнтий, Мөрөн сум/	2024 2026	4.3.1.3.
3	Үүрэн холбооны сүлжээ /Хэнтий, Норовлин, Галшар, Батноров, Биндэр, Баян-Адарга, Дадал, Дархан, Баянмөнх сум/	2024 2026	4.4.2.3.2
4	Ерөнхий боловсролын сургуулийн их засвар /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/	2025 2025	2.2.1.6.2
5	Хатуу хучилттай авто зам, 4.1 км /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/	2024 2025	1.1.1.1.2

¹ “Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.”,

² “Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн орчны стандарт үзүүлэлтүүдийг дээшлүүлнэ.”,

³ “Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэх”

6	Сургуулийн барилга, 640 суудал /Хэнтий, Өмнөдэлгэр сум/	2020 2025	2.2.1.6.2
---	--	--------------	-----------

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын 2024 оны 12 сарын 19-ний өдрийн 04 дүгээр тогтоол батлагдсан “Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”

Дараа онд хэрэгжүүлэх ажлын бэлтгэл хангахад чиглэсэн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах төсөл, арга хэмжээ мөн цахим систем, тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээг орон нутагт эрх шилжүүлээгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх орон нутагт эрх шилжүүлсэн 2 төсөл, арга хэмжээний нийгмийн ач холбогдлыг тооцож, заавар журмын дагуу эрэмбэлсэн байна.

Хэрлэн суманд орон сууцны барилгажилт нэмэгдэж байгаа, гэр хорооллын айл өрхийг инженерийн шугам сүлжээнд холбож ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх зэрэг зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Чингис хотын бохир усны төв коллекторын 1,2,3,4 дүгээр шугамын шинэчлэл, даралтат шугам, өргөх станц /Хэнтий, Хэрлэн сум/ төсөл, арга хэмжээг, Боловсролын салбарын барилгын нэн шаардлагатай засварын ажлуудын хүсэлтийг үндэслээд Ерөнхий боловсролын сургуулийн их засвар /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/ төсөл, арга хэмжээг тус тус төлөвлөсөн байна.

1.2. ТЭЗ нь төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулж тэнцүү хуваарилж төлөвлөөгүй байна.

Орон нутагт эрх шилжүүлсэн шинээр эхлэх 2 төсөл, арга хэмжээний зураг, төсвийг магадлалаар хянуулж, газрын зөвшөөрөл, холбогдох техникийн нөхцөлтэй шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Хүснэгт 2. Магадлалаар баталгаажсан зураг төсөв, газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлтэй эсэх

№	Төсөл, арга хэмжээний нэр	МЕД-ийн огноо	Газрын зөвшөөрөлтэй эхэс	Техникийн нөхцөлтэй эсэх
1	Чингис хотын бохир усны төв коллекторын 1,2,3,4 дүгээр шугамын шинэчлэл, даралтат шугам, өргөх станц /Хэнтий, Хэрлэн сум/	2025.05.27	Тийм	Тийм
2	Ерөнхий боловсролын сургуулийн их засвар /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/	2024.12.03	Тийм	Тийм

Эх сурвалж: МЕД, төсөл арга хэмжээний хувийн хэрэг



Дүрслэл 1. Төсөл, арга хэмжээний ангилал

“ УТХО-аар орон нутагт ТЭЗҮ, цахим систем, тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрх шилжиж ирээгүй байна.”

Тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Чингис хотын бохир усны төв коллекторын 1,2,3,4 дүгээр шугамын шинэчлэл, даралтат шугам, өргөх станц /Хэнтий, Хэрлэн сум/” төсөл арга хэмжээг 2025-2027 онд 8,181.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хэрэгжүүлэхээр төлөвлөж 2025 онд 2,113.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан нь Төсвийн тухай хуулийн 29.3.5⁴-д, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.3.4.2⁵ дахь заалтуудтай нийцүүлж төлөвлөөгүй байна.

Шийдвэрлэлт: /УАГ-т санал хүргүүлэх/

Өмнөх оноос шилжиж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 4 төсөл арга, хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг дээрх хууль тогтоомжтой нийцүүлэн төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Өмнөх оноос шилжих төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжүүлэхээр төлөвлөсөн дүн

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг /төгрөг/	2025 онд Санхүүжих дүн /төгрөг/
1	Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Хэнтий, Мөрөн сум/	2024 2026	3,430,100,000.0	1,138,200,000.0
2	Үүрэн холбооны сүлжээ /Хэнтий, Норовлин, Галшар, Батноров, Биндэр, Баян-Адарга, Дадал, Дархан, Баянмөнх сум/	2024 2026	2,924,700,000.0	1,023,700,000.0
3	Хатуу хучилттай авто зам, 4.1 км /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/	2024 2025	5,995,900,000.0	-
4	Сургуулийн барилга, 640 суудал /Хэнтий, Өмнөдэлгэр сум/	2020 2025	9,351,200,000.0	19,174,400.0

⁴ “Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах;”

⁵ “шинээр эхлэх барилга байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах.”

	ДҮН		21,701,900,000.0	2,181,074,400.0
--	------------	--	-------------------------	------------------------

Чингис хотын бохир ус татан зайлуулах нэгдсэн шугамыг шинэчилснээр Чингис хотын 24 мянган хэрэглэгчдийн өсөн нэмэгдэх хэрэгцээг 2050 он хүртэл хангах, бохир ус цэвэрлэх 3000м³ багтаамжтай цэвэрлэх байгууламжийг бүрэн ашиглах боломжтой болж байна

БҮЛЭГ 2. Захиалагчаас ажлын тоо хэмжээг хүргүүлэхдээ төлөвлөгөөнд заасан хугацааг баримтлаагүйгээс худалдан авах ажиллагааг хугацаанд нь зохион байгуулах боломжгүй болсон байна.

2.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хуулийн хугацаанд боловсруулан батлуулсан ч захиалагчаас ажлын тоо хэмжээг гаргаж төлөвлөгөөнд заасан хугацаанд хүргүүлээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь заалтын хүрээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 25 дугаар тушаалаар “Чингис хотын бохир усны төв коллекторын 1,2,3,4 дүгээр шугамын шинэчлэл, даралтат шугам, өргөх станц /Хэнтий, Хэрлэн сум/”, 45 дугаар тушаалаар “Инженерийн бэлтгэл арга хэмжээ-Бэрх тосгоны үерийн хамгаалалтын барилга байгууламж, хөрсний ус зайлуулах шугам сүлжээ /Хэнтий, Батноров сум/”, Сангийн сайдын 2025 оны 44 дүгээр тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн их засвар /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг аймгийн Засаг даргад тус тус шилжүүлсэн байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь төсвийн ерөнхийлөн захирагчаас эрх шилжүүлсэн шийдвэртэй төсөл, арга хэмжээ болон аймгийн ИТХ-аас баталсан орон нутгийн 2025 оны хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, замын сан, их засварын 51 төсөл, арга хэмжээ бүхий худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулсан Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1⁶-д заасан хугацаанаас хоцроон shilendans.gov.mn цахим системд байршуулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалтыг үндэслэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд багтаан тендерийг зохион байгуулж дуусгах боломжтойгоор үнэлгээний хороог байгуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байсан ч ажлын гүйцэтгэл хангалтгүй тул гэрээг цуцлан дахин худалдан авах ажиллагааг 2025 онд зохион байгуулсан “Чингис хотын бохир усны төв коллекторын 1,2,3,4 дүгээр шугамын шинэчлэл, даралтат шугам, өргөх станц /Хэнтий, Хэрлэн сум/” болон “Ерөнхий

⁶ 6.1.1.тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;

боловсролын сургуулийн их засвар /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/” төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээг аймгийн ЗДТГ-ын даргын 9/875, 8/877 албан бичгээр 2025 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр аймгийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн байна.

Захиалагчаас ажлын тоо хэмжээг хүргүүлэхдээ аймгийн Засаг даргын баталсан 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд худалдан авах ажиллагаа зарлахаар төлөвлөсөн хугацаанаас 22-78 хоногоор хоцроосон байна.

Захиалагчаас төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээ, онцлог, цар хүрээнд тулгуурлан ерөнхий шаардлага, санхүүгийн чадавхын шаардлага, техникийн

чадавх болон туршлагын шаардлага, Дүрслэл 2. Төлөвлөгөөнөөс хоцорсон хугацаа тусгай зөвшөөрлийн шаардлага зэргийн тендерийн баримт бичигт тусган боловсруулж худалдан авах ажиллагааг зарласан байна.



Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 3 төсөл, арга хэмжээнээс “Чингис хотын бохир усны төв коллекторын 1,2,3,4 дүгээр шугамын шинэчлэл, даралтат шугам, өргөх станц /Хэнтий, Хэрлэн сум/” болон “Ерөнхий боловсролын сургуулийн их засвар /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/” төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд багтаан худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Харин “Инженерийн бэлтгэл арга хэмжээ-Бэрх тосгоны үерийн хамгаалалтын барилга байгууламж, хөрсний ус зайлуулах шугам сүлжээ /Хэнтий, Батноров сум/” төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны зөвлөмж 2025 оны 6 дугаар сарын 9-нд гарсан нь дээрх хуулийн хугацаа⁷-г хэтрүүлсэн тул ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулаагүй байна.

Шинээр худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан “Чингис хотын бохир усны төв коллекторын 1,2,3,4 дүгээр шугамын шинэчлэл, даралтат шугам, өргөх станц /Хэнтий, Хэрлэн сум/” төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд оролцсон 3 оролцогч нь тендерийн баримт бичиг заасан шалгуурыг бүрэн хангасан учир хамгийн бага үнийн санал ирүүлсэн оролцогчийг сонгон шалгаруулсан байна.

⁷ 13.1.1. батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;

Ерөнхий боловсролын сургуулийн их засвар /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/ төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд 6 оролцогч орж ижил төстэй ажлын шаардлага хангаагүй, үнийн санал бага, ажлын тоо хэмжээ төсөв буруу, хүний нөөцийн материал шаардлага хангаагүй гэсэн шалтгаанаар 5 оролцогч нь хасагдсан байна.

Инженерийн бэлтгэл арга хэмжээ-Бэрх тосгоны үерийн хамгаалалтын барилга байгууламж, хөрсний ус зайлуулах шугам сүлжээ /Хэнтий, Батноров сум/ төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаанд 2 оролцогч оролцсоноос 1 оролцогч нь тендерийн баримт бичгийн шаардлагыг хангаагүй байна.

2.2. Худалдан авах ажиллагааны явцад гомдол гараагүй байна.

Тайлант хугацаанд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны явцад Сангийн яам болон Монополын эсрэг газарт гомдол гараагүй байна.

БҮЛЭГ 3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 83.0 хувь нь хэрэгжсэн ч техникийн хяналт хэрэгжүүлсэн эсэх нь тодорхойгүй байна.

3.1. Төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн хугацаанд нь санхүүжүүлсэн байна.



Дүрслэл 3. Төсөл, арга хэмжээний хэрэгжилт

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрх шилжин хэрэгжиж байгаа 6 төсөл, арга хэмжээнээс 15,785.7 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ гэрээний хугацаанд бүрэн хэрэгжиж дууссан бол 11,611.3 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байгаа, 2,749.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Харин “Үүрэн холбооны сүлжээ /Хэнтий, Норовлин, Галшар, Батноров, Биндэр, Баян-Адарга, Дадал, Дархан, Баянмөнх сум/” төсөл, арга хэмжээ нь худалдан авах ажиллагаа зохион байгуулж гэрээ байгуулсны дараа оролцогч шүүхэд гомдол гаргасантай холбоотойгоор шүүхийн шийдвэр гараагүй учир хэрэгжээгүй байна.

Хэрэгжүүлэх эрх шилжсэн төсөл, арга хэмжээнд нийт 2,608.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгосноос “Чингис хотын бохир усны төв коллекторын 1,2,3,4

дүгээр шугамын шинэчлэл, даралтат шугам, өргөх станц /Хэнтий, Хэрлэн сум/", "Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Хэнтий, Мөрөн сум/"-ын ажлын гүйцэтгэгчид 2,535.3 сая, захиалагчийн хяналтын зардалд 46.1 сая, зохиогчийн хяналтын зардалд 20.0 сая, нормчлолын санд 3.6 сая төгрөгийг тус тус олгож, барьцаа хөрөнгийн дансанд 3.1 сая төгрөгийг байршуулсан байна.

"Ерөнхий боловсролын сургуулийн их засвар /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/", "Сургуулийн барилга, 640 суудал /Хэнтий, Өмнөдэлгэр сум/", "Хатуу хучилттай авто зам, 4.1 км /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/" төсөл, арга хэмжээний санхүүжилт аймгийн хөрөнгө оруулалтын дансаар дамжиж олгогдоогүй байна.

"Үүрэн холбооны сүлжээ /Хэнтий, Норовлин, Галшар, Батноров, Биндэр, Баян-Адарга, Дадал, Дархан, Баянмөнх сум/" төсөл, арга хэмжээ тайлант хэрэгжээгүй байна.

"Ерөнхий боловсролын сургуулийн их засвар /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/" төсөл, арга хэмжээ нь зураг төсвийн дагуу бүрэн хэрэгжиж улсын комиссоор ашиглалтад хүлээн авсан байна.

3.2. Төсөл, арга хэмжээнд захиалагчийн техник хяналт хэрэгжүүлсэн ч фото зургаар баримтжуулан тайлагнаагүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд аймгийн ГХБХБГ нь 2025 онд 3 төсөл, арга хэмжээнд захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлж ажлын 3,665.8 сая төгрөгийн гүйцэтгэлийг баталгаажуулснаас 1 төсөл, арга хэмжээнд 5 удаа захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ажлын тайланг фото зургаар баримтжуулсан бол 2 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ажлын тайлан, фото зургийн баримт үйлдээгүй байна.

Дээрх ажлуудаас 2 төсөл, арга хэмжээ урьд жилүүдэд ашиглалтад орж санхүүжилтийн үлдэгдлийг авсан бол Бэрх тосгоны ЕБС-ийн засвар бүрэн дуусч ашиглалтад орсон байна.

Харин 2 төсөл, арга хэмжээ гэрээний хугацаанд он дамжин ажлын гүйцэтгэл 30-85%-тай үргэлжилж байгаа бол 1 төсөл, арга хэмжээ /Үүрэн холбооны сүлжээ /Хэнтий, Норовлин, Галшар, Батноров, Биндэр, Баян-Адарга, Дадал, Дархан, Баянмөнх сум/ тендерийн маргаантай байдлаас шалтгаалан хэрэгжээгүй байна.

Тайлант онд "Чингис хотын бохир усны төв коллекторын 1,2,3,4 дүгээр шугамын шинэчлэл, даралтат шугам, өргөх станц /Хэнтий, Хэрлэн сум/, "Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Хэнтий, Мөрөн сум/" төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн талаар ажлын тайлан гаргаагүй, фото зургаар баримтжуулаагүй байна.

Шийдвэрлэлт: /Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт албан шаардлага/

Дээрх ажлуудаас "Ерөнхий боловсролын сургуулийн их засвар /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/" төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт 5 удаа хэрэгжүүлж, фото зургаар тайлагнаж хадгаламжийн нэгжид баримтжуулсан байна.

Бэрх тосгоны ЕБС-ын их засварт ашигласан модон материалд галд тэсвэржилтийн дүгнэлтийг Гамшиг судлалын хүрээлэнгийн 2025.08.14-ны №D12034 тоотор, ОХУ-аас импортлосон усан суурьт будагт Барилга хөгжлийн төвийн №544/2024 тохирлын гэрчилгээ, өнгөлгөөний замаскт Барилга архитектурын корпорацийн 2023.05.01-ны №КБХЭ 18/23 шинжилгээ хийлгэн хадгаламжийн нэгжид баримтжуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Галбын тос" ХХК-ны гүйцэтгэж байгаа 438.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Ерөнхий боловсролын сургуулийн их засвар /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/-ын их засварын ажил бүрэн дууссан тул барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 8 сарын 13-нд ажиллан ашиглалтад хүлээн авсан байна.

Харин "Чингис хотын бохир усны төв коллекторын 1,2,3,4 дүгээр шугамын шинэчлэл, даралтат шугам, өргөх станц /Хэнтий, Хэрлэн сум/" ажил 30%-ийн гүйцэтгэлтэй, "Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Хэнтий, Мөрөн сум/" 85%-ийн гүйцэтгэлтэй гэрээний дагуу үргэлжилж байна.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 3 төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг стандартын⁸ дагуу хийж төсөл, хэрэгжүүлэх талбайд байршуулах талаар Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2⁹-т заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэлт: /Аймгийн Засаг даргад зөвлөмж/

Зураг 1. Чингис хотын инженерийн шугам сүлжээний ажил

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж 2024 онд ашиглалтад орсон "Сургуулийн барилга, 640 суудал /Хэнтий, Өмнөдэлгэр сум/", "Хатуу хучилттай авто зам, 4.1 км /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/" төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт төсвийн тухай хуульд тусгагдсан бол "Үүрэн холбооны сүлжээ /Хэнтий, Норовлин, Галшар, Батноров, Биндэр, Баян-Адарга, Дадал, Дархан, Баянмөнх сум/"

⁸ Улс, орон нутгийн төсөв болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр санхүүжих бүтээн байгуулалтын ажлын мэдээллийн самбарт тавих шаардлага MNS 7023:2023,

⁹ 37.1.2. "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.6.10, 8.6.11-д заасны дагуу барилга байгууламж болон үйл ажиллагааныхаа талаархи иж бүрэн мэдээллийг тухайн нутаг дэвсгэрт нийтэд ил тод байрлуулах;"

төсөл, арга хэмжээ худалдан авах ажиллагаанд гарсан маргааны улмаас 2025 онд хэрэгжээгүй.

3.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлыг бүрэн бүртгэж, зориулалтын дагуу ашиглаж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын нийт 7 төсөл, арга хэмжээнээс 15,785.6 сая төгрөгийн хөрөнгийг "Ерөнхий боловсролын сургуулийн их засвар /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/" төсөл, арга хэмжээг Бэрх тосгоны ЕБС-ын үндсэн хөрөнгөнд, "Сургуулийн барилга, 640 суудал /Хэнтий, Өмнөдэлгэр сум/" ажлыг Өмнөдэлгэр сумын ЕБС-ын үндсэн хөрөнгөнд, "Хатуу хучилттай авто зам, 4.1 км /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/" ажлыг Бэрх тосгоны Бэрх хөгжил ААТҮГ-ын үндсэн хөрөнгөнд тус тус бүртгэсэн байна.


д/д	Төсөл, арга хэмжээ	Бүртгэсэн		
		байгууллага	Тушаалын дугаар	Дүн /төгрөг/
1	Ерөнхий боловсролын сургуулийн их засвар /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/	Бэрх ЕБС	2025.12.26 №А/39	438,624,900.0
2	Сургуулийн барилга, 640 суудал /Хэнтий, Өмнөдэлгэр сум/	Өмнөдэлгэр ЕБС		9,351,175,057.0
3	Хатуу хучилттай авто зам, 4.1 км /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/	Бэрх хөгжил ААТҮГ	2024.12.28 №А/10	5,995,859,600.0
ДҮН				15,785,659,519.0

Хүснэгт 4. Хөрөнгө бүртгэсэн байдал

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ЕБС-ийн их засварын дүнд Өмнөдэлгэр сум, Бэрх тосгоны ЕБС-ийн 1500 гаруй хүүхдийн сурах орчныг сайжруулсан бол хатуу хучилттай автозам ашиглалтад оруулснаар Бэрх тосгоны оршин суугчдын зорчих хөдөлгөөнийг сайжруулж зориулалтын дагуу бүрэн ашиглаж байгаа бол Мөрөн сумын иргэдэд үйлчлэх төв, "Үүрэн холбооны сүлжээ /Хэнтий, Норовлин, Галшар, Батноров, Биндэр, Баян-Адарга, Дадал, Дархан, Баянмөнх сум/" төсөл, арга хэмжээ ашиглалтад орсноор төрийн үйлчилгээ болон дэд бүцийн хүртээмж сайжирч 430 гаруй малчин өрхөд харилцаа холбооны үйлчилгээ хүрч улс, аймгийн дунд хугацааны бодлогын зорилтын үр дүнг нэмэгдүүлэхээр байна.

"Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын албан шаардлагаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр барилга байгууламжийг ашиглалтад оруулдаг, зөвлөмжөөр өгсөн ХАА-нд зааснаас өөрөөр гэрээг сунгахгүй байх, гүйцэтгэгч календарчилсан төлөвлөгөөг мөрдөх, ашиглалтад орсон барилга байгууламжийг бүрэн ашиглах зэрэг шийдвэрийг хэрэгжүүлсэн байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



Аудитын тайлангийн төсөлд санал ирүүлээгүй тул аудитын тайланд өөрчлөлт оруулаагүй болно.

Нийцлийн аудитаар нийт 2,113.4 сая төгрөгийн 3 зөрчил илрүүлснээс зөрчлийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлагыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, зөрчил арилгах 1 зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлж, аудитын дүнд үндэслэн 1 саналыг Үндэсний аудитын газарт хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- УТХО-аар 2025 онд шинээр хэрэгжүүлэх 1 төсөл арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулан тэнцүү хуваарилж төлөвлөөгүй байна.
- Зохиогч болон захиалагч нь хяналт хэрэгжүүлсэн талаар тайлан бэлтгэж, фото зургаар баримтжуулах чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.
- Захиалагч нь төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээг төлөвлөгөөнд заасан хугацаанд хүргүүлээгүй, мэдээллийн самбарыг холбогдох хууль, стандартын дагуу байршуулаагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.АЮУРБУНЬ-Д

- Төсөл, арга хэмжээний ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолтыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацаанд багтаан хүргүүлэх, мэдээллийн самбарыг стандартын дагуу байршуулах талаар холбогдох хуульд заасан захиалагчийн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах

ҮАГ-Т ТАВИХ САНАЛ:

- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны төсвийн XVIII.1.1 багцад батлагдсан шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг хэрэгжих хугацаатай уялдуулж тэнцүү хуваарилж төлөвлөх.

Хэнтий аймаг, Хэрлэн сум, 4-р баг,
Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхарт
Утас: +976 70562112
И-мэйл хаяг: khentii@audit.gov.mn, Веб сайт: www.audit.mn

АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН БҮРТГЭЛ

Аудитын нэр: Улс, орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн
Аудитын код: ХЭА-2026/05-22-ШТА-НА
Байгууллагын нэр: Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар

№	Аудитын чиглэл, асуулт	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн (төгрөг)	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	Гаргасан шийдвэр
Аудитын дэд зорилт А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ оновчтой төлөвлөсөн үү?						
А.1.2. Төсөвлөлтийн шаардлага хангасан, өртөг, санхүүжилт, хүрэх үр дүнг оновчтой тодорхойлсон төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү?						
1	А.1.2.3. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулан тэнцүү хуваарилж төлөвлөсөн үү?	Хот байгуулалт, барилга, орон сууцруулалтын сайдын Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах улсын төсвийн хөрөнгө багцад хамаарах Чингис хотын бохир усны төв коллекторын 1,2,3,4 дүгээр шугамын шинэчлэл, даралтат шугам, өргөх станц /Хэнтий, Хэрлэн сум/ төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулан тэнцүү хуваарилаагүй байна.	2,113,400,000.00	ҮАГ-Т САНАЛ: Хот байгуулалт, барилга, орон сууцруулалтын сайдын 2025 оны төсвийн XVIII.1.1 багцад батлагдсан шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг хэрэгжих хугацаатай уялдуулж тэнцүү хуваарилж төлөвлөхгүй байна.	<i>саналгүй</i>	
Дэд зорилт А.3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж төлөвлөсөн үр дүнд хүрсэн үү?						
А.3.2. Барилга байгууламжийн үе шат бүрд захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлсэн үү?						
2	А.3.2.1. Барилга байгууламжийн үе шат бүрд зохиогчийн болон захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлсэн үү?	Тайлант онд аймгийн ГХБХБГ нь "Чингис хотын бохир усны төв коллекторын 1,2,3,4 дүгээр шугамын шинэчлэл, даралтат шугам, өргөх станц /Хэнтий, Хэрлэн сум/, "Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Хэнтий, Мөрөн сум/" төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн талаар ажлын тайлан, фото зургаар баримтжуулаагүй байна.		АЛБАН ШААРДЛАГА 1: Барилга байгууламжийн үе шат бүрд хэрэгжүүлсэн зохиогчийн болон захиалагчийн хяналтын ажлыг тайлагнадаггүй, фото зургаар баримтжуулаагүй зөрчлийг таслан зогсоох	<i>саналгүй</i>	
3	А.3.2.5 Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг стандартын дагуу хийж байршуулсан эсэхэд хяналт хэрэгжүүлж байна уу?	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 3 төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг стандартын дагуу хийж төсөл, хэрэгжүүлэх талбайд байршуулах талаар Барилгын тухай хуульд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.		ЗӨВЛӨМЖ 1: Хуульд заасан захиалагчийн чиг үүргийн дагуу хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг MNS:7023:2023 стандартад заасны дагуу байршуулах	<i>саналгүй</i>	
Аудитын дэд зорилт Б.1. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөсөн үү?						
Б.1.1. Аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулж, нэн тэргүүнд хэрэгцээ, шаардлагатай төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү?						
4	Б.1.1.4. Сумын ИТХ-аас баталсан орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь орон нутгийн дунд хугацааны бодлогын баримт бичигтэй нийцэж, төлөвлөлтийн шаардлага хангаж байна уу?	1. Баянмөнх, Биндэр, Өмнөдэлгэр сумд орон нутгийн хөрөнгө оруулалтын 142.5 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг сумын ИТХ-аар батлуулахгүйгээр хэрэгжүүлсэн. 2. Бор-Өндөр, Цэнхэрмандал сумд урсгалын шарилжтай 87.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээг төлөвлөж сумын ИТХ-аар батлуулсан. 3. Бор-Өндөр сум Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрөөс санхүүжих 18 төсөл, арга хэмжээг орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад оруулж ИТХ-аар батлуулсан нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан журамд заасан орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн шаардлага хангахгүй байна.		ЗӨВЛӨМЖ 2: Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хууль, Засгийн газрын 278 дугаар тогтоолд нийцүүлэн орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэх, хэрэгжилтийг үнэлэх ажлыг зохион байгуулах	<i>саналгүй</i>	
Б.1.2. Төсөвлөлтийн шаардлага хангасан, өртөг, санхүүжилт, хүрэх үр дүнг оновчтой тодорхойлсон төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү?						
5	Б.1.2.1. Магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй, газрын зөвшөөрөл, техникийн нөхцөлтэй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн үү?	Магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй, техникийн нөхцөлгүй 324.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээг 4 сумын ИТХ-аар, 420.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сумын төвийн гэрэлтүүлэг, камержуулалт /Жаргалтхаан/ барилга байгууламжийн төсөл, арга хэмжээг зураг төсөв, техникийн нөхцөлгүй байхад аймгийн ИТХ-аар тус тус төлөвлөж батлуулсан байна.	977,623,600.00	АЛБАН ШААРДЛАГА 2: Магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх шаардлагыг хангаагүй барилга байгууламжийг төлөвлөдөг зөрчлийг таслан зогсоох	<i>саналгүй</i>	
6	Б.1.2.2. Ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, тооцоололд үндэслэн ТЗҮУ, зураг төсөл, тоног төхөөрөмжийн өртгийг төлөвлөсөн үү?	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажлын даалгаваргүй 235.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээ, техникийн тодорхойлолтгүй 206.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.	442,395,890.00	АЛБАН ШААРДЛАГА 3: Батлагдсан ажлын даалгавар, техникийн тодорхойлолтгүй төсөл, арга хэмжээг төлөвлөдөг зөрчлийг таслан зогсоох	<i>саналгүй</i>	
Дэд зорилт Б.2. Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж хяналт тавьсан үү?						
Б.2.1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу, хугацаанд нь зохион байгуулсан үү?						
7	Б.2.1.4. Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд зохион байгуулж дуусгасан үү?	Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанаас хэтрүүлэн 493.2 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээ байгуулсан байна. Үүнээс 300.5 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг тодотголоор нэмж баталсан боловч төсөв батлагдсан даруйд худалдан авах ажиллагааг хэрэгжүүлээгүй байна.	493,150,406.00	ЗӨВЛӨМЖ 3: Аймгийн хэмжээнд худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд багтаан зохион байгуулж дуусгавар болгох, худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох	<i>саналгүй</i>	

8	Б.2.1.5. Төндөр шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага хангасан оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан уу?	1. "Сумын эрүүл мэндийн төвийн машин", "Сумдын Засаг даргын Тамгын газрын автомашин"-ы гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хорооны хуралд аймгийн Засаг даргын 2025 оны "Үнэлгээний хороо байгуулах тухай" А/201 дүгээр захирамжаар томилоогүй иргэний төлөөлөл оролцсон. 2. Үнэлгээний хороо нь 100.0 сая төгрөгийн төсөвт өртөг, санхүүжих дүнтэй "Сумын эрүүл мэндийн төвийн машин" төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй санал ирүүлсэн гүйцэтгэгчийг шалгаруулсан байна. 3. Техникийн тодорхойлолтод заасан шаардлага хангахгүй санал ирүүлсэн оролцогчийг шалгаруулснаар зах зээлийн үнээс өндөр үнэтэй хөрөнгийг бэлтгэсэн байна.	100,000,000.00	АЛБАН ШААРДЛАГА 4: Техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй санал ирүүлсэн оролцогчийг шалгаруулдаг зөрчлийг таслан зогсоох	саналгүй	
Дэд зорилт Б.3. Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн үү?						
Б.3.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь санхүүжүүлж, гүйцэтгүүлсэн үү?						
9	Б.3.1.1. Төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлсэн үү?	Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан "Батширээт сумын ЗДТГ-ын байрны засвар" төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг Батширээт сумын Засаг даргад шилжүүлсэн боловч захирамжийн хэрэгжилт хангалтгүйгээс гэрээний хугацаанд хэрэгжиж дуусаагүй байна.		АЛБАН ШААРДЛАГА 5: Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлсэн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьдаггүй зөрчлийг таслан зогсоох	саналгүй	
10	Б.3.1.3. Төсөл, арга хэмжээг ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсвийн дагуу гүйцэтгүүлсэн үү?	Аймгийн Засаг даргын 2025 оны А/46 дугаар захирамжаар томилсон ажлын хэсэг нь "Сумдын ЗДТГ-ын авто машин" төсөл, арга хэмжээний хүрээнд худалдан авах ажиллагаанд ирүүлсэн техникийн тодорхойлолтод нийцээгүй, зөрүүтэй 176.5 сая төгрөгийн "Toyota 4Runner" маркийн автомашиныг хүлээн авсан байна.	176,500,000.00	АЛБАН ШААРДЛАГА 6: Худалдан авах ажиллагаанд шалгарсан техникийн тодорхойлолтоос зөрүүтэй тоног төхөөрөмж хүлээн авдаг зөрчлийг таслан зогсоох	саналгүй	
Б.3.2. Барилга байгууламжийн үе шат бүрд захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлсэн үү?						
11	Б.3.2.1 Барилга байгууламжийн үе шат бүрд зохиогчийн болон захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлсэн үү?	Орон нутгийн хөрөнгө оруулалтын 3,608.8 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт, 1,857.2 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээнд зохиогчийн хяналт хэрэгжүүлсэн гэх боловч ажлын баримт бүрдүүлж, хадгаламжийн нэгжид оруулаагүй байна.		АЛБАН ШААРДЛАГА 1: Барилга байгууламжийн үе шат бүрд хэрэгжүүлсэн захиалагчийн хяналтын ажлын баримтыг бүрдүүлж, хадгаламжийн нэгжид оруулдаггүй зөрчлийг таслан зогсоох	саналгүй	
12	Б.3.2.3 Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд комисс заавар журмын дагуу хяналт тавьж ашиглалтад хүлээн авсан уу?	1. Гүйцэтгэгчээс барилга, угсралт, их засварын ажлыг ашиглалтад оруулах хүсэлт гаргаагүй 3,602.1 сая төгрөгийн 15 төсөл, арга хэмжээнд улсыг комисс ажилласан. 2. Хөрөнгө оруулалтын 373.9 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээг хүлээн авах комисс ажиллаагүй байна.		ЭӨВЛӨМЖ 4: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ бүрд Засгийн газрын тогтоолоор баталсан журамд заасан барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг бүрэн ажиллуулах	саналгүй	
13		Засгийн газрын 2021 оны 212 дугаар тушаалаар баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийг зөрчин Хэрлэн сумын Засаг дарга, ЗДТГ-ын дарга нар нь ашиглалтад оруулах комиссыг томилон барилга байгууламж, их засварын 2 төсөл, арга хэмжээг хүлээн авсан байна.		АЛБАН ШААРДЛАГА 7: Засгийн газрын тогтоолоор баталсан дүрэмд нийцэхгүй комиссыг ажиллуулдаг зөрчлийг таслан зогсоох	саналгүй	
НИЙТ ДҮН			4,303,069,896.00			

Бэлтгэсэн:

Аудитор:

Ахлах аудитор:

Ахлах аудитор:

Анхан шатанд хянасан:

Аудитын менежер:

Хоёр дахь шатанд хянасан:

Дарга, тэргүүлэх аудитор:

Т.Алтаншагай

Ц.Билэгсайхан

Д.Эрдэнэбилэг

Д.Оюунтуяа

Ж.Ганбаатар

Огноо

Огноо

Огноо

Огноо

Огноо

Танилцсан:

Хэнтий аймгийн Засаг дарга

Хэнтий аймгийн ЗДТГ-ын дарга

Хэнтий аймгийн ЗДТГ-ын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Худалдан авах ажиллагааны газрын дарга

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Хэрлэн сумын Засаг дарга биеийн Чингис хотын захирал

Д.Аюурбуны

А.Жаргалсайхан

Д.Баярхүү

Т.Батзорж

Б.Сүмбээ

Д.Эрдэнэбаатар

Огноо

Огноо


Огноо

Огноо

Огноо

Огноо

Огноо



181910012
ИМТ1449-3* 76192